*Орчуулсан: Саранборжигин Ц.Дашзэвэг*




Английн тvvхч, зохиолч, аялагч Жон Мэн “Чингис хааны манлайллын нууц” хэмээх энэ номоороо Чингис хааныг жинхэнэ аугаа их гарамгай манлайлагч болгосон тэрхvv манлайллын нэн чухал нууцыг нээн гаргасан байна. Чингис хаан оорийн мэдлэг, дадлаа Их Монгол Улсыг хийгээд улмаар Монголын эзэнт гvрнийг  байгуулах vйлсдээ  vр бvтээлтэй ашигласан тvvний чадварын нууцыг тэрээр орчин vеийн манлайллын онолын тусламжтайгаар нарийвчлан шинжилж, “Чингис хаан бол жинхэнэ аугаа их гарамгай манлайлагч” болохыг нотлон харуулжээ.

Зохиогч энэ бvтээлдээ Чингис хаан эхлээд цэрэг дайчин, дараа нь торийн бодлоготон, улмаар нийгмийг шинэчлэгч гэсэн манлайллын гурван vе шатыг дамжсан болохыг тэмдэглээд тvvний манлайллын нууцуудыг тvvний vйл хэргийн амжилтаар нь vндэслэн гаргаж тавьсан байна.

Тэрбээр Чингис хааны манлайллын  хорин нэгэн нууцыг энэ номондоо дурьдсан байх юм.

Бие хvний мэдлэг, дадлаа  vр дvнтэй ашиглах арван найман чадварыг орчин цагийн манлайллын зарим онолчид нэрлэсэн байдаг.  Тэдний vзэж байгаагаар маш бvтээмжтэй манлайлагч нарт мэдлэг, дадлаа vр дvнтэй ашиглах дээрхи 18 чадварын 6 орчим нь байдаг гэнэ. Энэ бол дээд боломж гэж тэд нотолж байна. Тэгвэл Эзэн Богд Чингис хаан дээрх 18 чадварын 15-ыг нь оорийн бvхий л амьдралын туршид илэрvvлэн гаргаж байсан байна гэж Жон Мэн нотлоод “Чингис хаан бол аугаа их суут манлайлагч байжээ” гэсэн дvгнэлтэнд хvрсэн тухай энэхvv номонд огvvлнэ.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэн